



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/ЧО1

Арвайхээр сум

Албан ажлаар оролцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 01/03 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.1.1, 3.4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Солонгос Улсын Гёнсанбүг мужийн Гёнжү хотод 2023 оны 06 дугаар сарын 28-аас 06 дугаар сарын 30-ны хооронд зохион байгуулагдах Зүүн Хойд Азийн Нутгийн Захиргаадын Холбооны (NEAR) хуралд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Бямбадоржийн Сайнжаргалыг оролцуулсугай.

2.Аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах төсөл хөтөлбөр, хамтын ажиллагаанд бодитой хувь нэмэр оруулж, хэрэгжүүлж ажиллахыг дээрх албан тушаалтанд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6723 11 0776

D:My Doc. Zahiramj. Zasag darga